



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1536  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН З.ХҮРЭЛБААТАР  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Зинэмидэрийн Хүрэлбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Зинэмидэрийн Хүрэлбаатарын Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр


ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Зинэмидэрийн Хүрэлбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөр (1. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар дүүргийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 1 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



2020 оны ээлжит орон нутгийн сонгуульд Сүхбаатар дүүрэгт бие даан нэр дэвшигч Зинэмидэр овогтой Хүрэлбаатарын

**МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

- 1. Төрийн албан хаагчдын харилцаа, ёс зүй хариуцлагыг сайжруулж ажиллана.**
  - 1.1 Төрийн албан хаагчдын ёс зүйгүй харилцааны алдаа дутагдлаас болж төрийн албаны нэр хүнд унаж буй байдлыг таслан зогсоохын төлөө ажиллана
  - 1.2 Иргэдэд шударга бус ялгавартай харьцдаг, үйлчилдэг төрийн албан хаагчдын ёс зүйгүй үйлдлийг илрүүлж хариуцлага тооцож ажиллана.
  - 1.3 Иргэдэд халтай харин эрх мэдэлтэн нөлөөтэй хүмүүст ээлтэй ханддаг шударга бус үйлдэлтэй хатуу тэмцэж ажиллана.
  - 1.4 Дүүрэг хорооны ажилчид /Засаг дарга, төрийн албан хаагчид, хэсгийн ахлагч/ иргэдэд намчирхан ажилладаг байдлыг таслан зогсооно.
- 2 Нийгмийн халамж үйлчилгээ хөдөлмөр эрхлэлтийг тэгш хүртээмжтэй хүргэж ажиллана.**
  - 2.1 Дүүрэг хороонд халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллана.
  - 2.2 Хувиараа хөдөлмөр эрхэлж буй хувь хүн, аж ахуй нэгжийг төрөөс олгодог хөнгөлөлттэй зээлд тэгш хамруулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
  - 2.3 Амьжиргааны түвшин доогуур айл өрх иргэдийн судалгаа гаргаж тэдэнд тэгш хүртээмжтэй халамж үйлчилгээг хүргэнэ.
  - 2.4 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 3 Орчны тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажиллана.**
  - 3.1 Тус хороонд үйл ажиллагаа явуулдаг сууц өмчлөгчдийн холбоодтой тохижилт хог хаягдлын менежментийг сайжруулах талаар ил тод нээлттэй хэлэлцүүлж алдаа дутагдлыг нь шуурхай шийдвэрлэнэ.
- 4 Бусад**
  - 4.1 УИХ-ын 2020 оны 52-р тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” заалтад хамаарч буй 3-р зорилтын Амьдралын чанар ба дундаж давхарга “Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхрагыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ” гэсэн заалтыг гол чиглэл болгон ажиллана.

Бие даан нэр дэвшигч  З.Хүрэлбаатар

Утас:94205407

